

ХОЁР.НИЙГМИЙН БОДЛОГО

Иргэн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлж, эрүүл мэндийн чанар, хүртээмжийг сайжруулж, хүн амын тогтвортой, өсөлт, хөгжлийг дэмжиж, идэвхтэй, бүтээлч, ажилтай, орлоготой иргэн, гэр бүлийг төлөвшүүлэн хүний амьдралын чанарыг сайжруулна.

2.1 Эрүүл мэнд

2.1.1 “Эрүүл Дарханчууд” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.1.2 Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр орон нутагтаа **тусгайлсан бодлогыг** хэрэгжүүлнэ.

2.1.3 Эмнэлгийн тусламж, үйлчилгээг шуурхай, ил тод, хариуцлагатай байлгах зорилгоор “**Цахим эмнэлэг**” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.1.4 Эрүүл мэндийн төвийн өргөтгөл хийж, эмчилгээ, оношилгооны чанар, хүртээмжийг сайжруулна.

2.1.5 “**Энх бүсгүй**” хөтөлбөр хэрэгжүүлж, нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлыг зохистой бодлогоор хангана.

2.1.6 “**Эрүүл чийрэг эр хүн**” хөтөлбөр хэрэгжүүлж, эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг эрсдэлт хүчин зүйлүүдийг бууруулна.

2.1.7 Хүн амын дунд зонхилон тохиолддог өвчний судалгааг хийж, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

2.1.8 Оюутан, залуучуудыг эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулж, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулна.

2.1.9 Эрүүл мэндийн салбарын ажиллагсдыг чадавхижуулж, тэдний нийгмийн асуудлыг шат дараатай шийдвэрлэнэ.

2.2.Боловсролын салбар

2.2.1 Боловсролын байгууллагын сургалтын чанарыг сайжруулна.

2.2.2 Цэцэрлэг, сургууль бүрийн материаллаг баазыг сайжруулж, хүүхэд эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох нөхцлийг бүрдүүлнэ.

2.2.3 Цэцэрлэг, сургуулийн гадна болон дотор орчны засвар үйлчилгээ, тохижилт, өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор “**Гоё цэцэрлэг**”, “**Гоё сургууль**” төслүүдийг хэрэгжүүлж, сургуулийн гадгах талбайд спортын талбайг иж бүрнээр байгуулна.

2.2.4 Сурагчдад сонирхол, авьяас чадвараа харгалзан ирээдүйн мэргэжлээ зөв сонгоход нь мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор ахлах ангийн сурагчдын дунд “**Миний ирээдүй**” төсөл хэрэгжүүлнэ.

2.2.5 Суманд нэн шаардлагатай нарийн мэргэжлийн ажилтанбэлтгэх зорилгоор орон нутгийн захиалгаар дотоод, гадаадын их, дээд сургуулиудад гэрээгээр бэлтгэж, тогтвортой ажлын байраар хангах “**Захиалгат мэргэжилтэн**” төслийг хэрэгжүүлнэ.

2.2.6 Бүх нийтийн боловсрол болон алсын зайны сургалтыг дэмжиж ажиллана.

2.2.7 Энхтал багийн Бүрэнтолгой хэсэгт байнгын үйл ажиллагаатай цэцэрлэг байгуулна.

2.2.8 Сумын төвийн цэцэрлэгтөргөтгөл хийж, СӨБ-ын хүүхдийн хамран сургалтыг 100 хувьд хүргэх

2.3 Соёл урлаг, спорт

2.3.1 Соёлын төвийн үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, материаллаг баазыг нь бэхжүүлж, боловсон хүчний чадавхийг сайжруулна.

2.3.2 Түүх, соёлын үнэт зүйлс, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.

2.3.3 Соёл, урлаг, спортын хичээллэх секц, дугуйланг бодлогоор дэмжиж ажиллана.

2.3.4 Номын сангийн фонд, орон нутаг судлах танхимын төрөл, тоог тогтмол нэмэгдүүлнэ.

2.3.5 Хүүхэд, залуучуудын дунд шинэ тутам хөгжиж буй спортын төрлүүдийг дэмжинэ.

2.3.6 Соёлын төвийн их засварын ажил хийх буюу 2 давхрыг ашиглалтад оруулах

2.4 Хөдөлмөр эрхлэлт

2.4.1 Мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажил эрхлээгүй хөдөлмөрийн насны иргэдийг мэргэшүүлэх, ур чадварыг нь ахиулах богино хугацааны сургалтанд хамруулж, **“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”** дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

2.4.2 Ажлын байраа хадгалсан, шинэ ажлын байр бий болгосон ажил олгогчдыг дэмжиж ажиллана.

ГУРАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙ

Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн, экспортод чиглэсэн, импортыг орлох бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг эрчимжсэн хөдөө аж ахуйтай хослуулан хөгжүүлж, хөдөө аж ахуй эрхлэгчдийг бүх талаар дэмжинэ.

3.1 Газар тариалан

3.1.1 **“Атар-4”** аяныг хэрэгжүүлэх ажлын хүрээнд инженерийн хийцтэй услалтын систем бүхий тариалангийн талбайд бага оврын усалгааны тоног төхөөрөмжийг ашиглах зорилгоор цахилгааны эрчим хүчний асуудлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.

3.1.2 Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийг дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.

3.1.3 **“Үр”** дэд хөтөлбөр, **“Хүлэмж”**, **“Зоорь”**, **“Бордоо”** төслүүд хэрэгжүүлнэ.

3.1.4 Таримлын сэлгээ, тэжээлийн үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.

3.1.5 Тариалангийн газрын үржил шимийг сайжруулж, хөрс тордох ажлыг зохион байгуулж, бэлчээрийн зүй зохистой менежментийг хэрэгжүүлнэ.

3.2 Мал аж ахуй

3.2.1 Мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжин хөгжүүлнэ.

3.2.2 Уламжлалт нүүдлийн мал аж ахуйг эрчимжсэн мал аж ахуй, туслах аж ахуй, газар тариалантай хослуулан хөгжүүлэх бодлого баримтална.

3.2.3 Сүү боловсруулах, сүү хөргөөх цехийн үйл ажиллагааг дэмжинэ.

3.2.4 Малын үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн малын нөхөн үржүүлгийг сайжруулахад био технологийн ололтыг ашиглах, малын үржүүлэг, технологийн нэгжийг чадавхижуулна.

3.2.5 Эрчимжсэн өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийнүүлдрийн үхрийнаж ахуйг хөгжүүлнэ.

3.3 Туслах аж ахуй

3.3.1 Зөгий аж ахуйн үйлдвэрлэл, бүтээгдэхүүн борлуулалтыг нэмэгдүүлэхийг дэмжинэ.

3.3.2 Туслах аж ахуйг хөгжүүлэхэд нь техник, технологийн дэмжлэг үзүүлнэ.

ДӨРӨВ. ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

Иргэдийнхээ ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг хангасан хэрэгцээ шаардлагад нь нийцсэнамар тайван, аюулгүй сум болон хөгжинө.

4.1 Дэд бүтэц

4.1.1 Цэвэрлэх байгууламжийг технологийн дагуу шинээр барьж ашиглалтад оруулна.

4.1.2 Дулаан хангамжийн нэгдсэн төв, станцын барилга байгууламж барьж, тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулна.

4.1.3 Гэр хорооллын айл өрхүүдийг төвлөрсөн инженерийн дэд бүтцэд холбох ажлыг зохион байгуулж, айл өрхийн хашааг нэгдсэн зохион байгуулалтаар стандартад нийцүүлнэ.

4.1.4 Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө (сумын төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө) хийлгэнэ.

4.1.5 Амины орон сууц хорооллын 82 айлын дэд бүтцийг үргэлжлүүлэн хийнэ.

4.1.6 “Уулзвар” төсөл хэрэгжүүлж, хороолол бүрийн гудамж, талбайд гэрэлтүүлгийг шийдвэрлэн гарц, тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч, хяналтын камержуулалт хийнэ.

4.1.7 Баян-Өлзийт багийн Тосгон, Шар дэрс хорооллын сайжруулсан замыг хатуу хучилттай болгоно.

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН

Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь нэмэгдүүлнэ.

5.1 Байгаль хамгаалал

5.1.1 Усны эх үүсвэрийг бохирдох, хомсдохоос урьдчилан сэргийлэх, гол горхи, булаг шандны эхийг хамгаална.

5.1.2 Ургамал, амьтны тархац, нөөцийн судалгааг үе шаттай хийж, зохистой менежментийг хэрэгжүүлнэ.

5.2 Ногоон үйлдвэрлэл, үйлчилгээ

5.2.1 Байгалийн нөөцийн хэмнэлттэй, агаар орчны бохирдол, хаягдал багатай үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээг хөгжүүлэхийг бодлогоор дэмжинэ.

5.2.2 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилах, дахин ашиглах, дахин боловсруулах цогц менежментийг хэрэгжүүлж, эдийн засгийн эргэлтэнд оруулахыг дэмжинэ.

ЗУРГАА. ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн, экспортод чиглэсэн, импортыг орлох бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг бүх талаар дэмжинэ.

6.1 Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ

6.1 Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг бодлогоор дэмжинэ.

6.2 Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг үзэсгэлэн яармагт оролцоход нь дэмжинэ.

6.3 Худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуй нэгж болон иргэдийг хөнгөлттэй зээл, тусламжид хамруулна.

6.4 Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгоно.

6.5 Орчин үеийн шаардлагад нийцсэн **олон улсын тээвэр, ложистикийн төв** байгуулахыг дэмжинэ.

6.6 Аялал, жуулчлалыг хөгжүүлэх ажлыг дэмжинэ.

6.7 Ахуйн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Дархан-Уул аймгийн Орхон сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцохоор Дархан-Уул аймгийн Орхон сумын Монгол Ардын намын хорооноос дэвшүүлсэн **“Тогтвортой бодлого-Тогтвортой хөгжил”** мөрийн хөтөлбөр нь нийт **6** бүлэг, **13** дэд бүлэг, **69** зорилттой.

Эх сурвалж:

1. Алсын хараа-2050
2. Намын үзэл баримтлал
3. Дархан хотын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө 2020-2035 он
4. Дархан-Уул аймгийн Орхон сумын хөгжлийн стратеги төлөвлөгөө 2016-2025
5. Өмнөх хөтөлбөрийн үргэлжлэл
6. Иргэдийн санал

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИТХ-ЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬДОРЛОЦОХООР ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОРХОН СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНООС ДЭВШҮҮЛСЭН
“ТОГТВОРТОЙ БОДЛОГО - ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ” МӨРИЙН ХӨТӨЛБӨР

АГУУЛГА

НЭГ. ТӨРИЙН УДИРДЛАГА

- 1.1 Иргэнд ээлтэй төрийн үйлчилгээ
- 1.2 Ухаалаг төрийн үйлчилгээ

ХОЁР. НИЙГМИЙН БОДЛОГО

- 2.1 Эрүүл мэнд
- 2.2 Боловсролын салбар
- 2.3 Соёл урлаг, спорт
- 2.4 Хөдөлмөр эрхлэлт

ГУРАВ. ХӨДӨӨАЖ АХУЙ

- 3.1 Газар тариалан
- 3.2 Мал аж ахуй
- 3.3 Туслах аж ахуй

ДӨРӨВ. ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

- 4.1 Дэд бүтэц

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН

- 5.1 Байгаль хамгаалал
- 5.2 Ногоон үйлдвэрлэл, үйлчилгээ

ЗУРГАА. ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

- 6.1 Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ

ДОЛОО. ХАВСРАЛТ

ХҮНДЭТ ОРХОНЧУУДАА!

Дархан-Уул аймгийн Орхон сумын Монгол Ардын Намын хорооны гишүүд дэмжигчид бид Орхончууд Та бүхэндээ **“ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХҮЧЭЭ НЭГТГЭЭ”** уриа бүхий **“ТОГТВОРТОЙ БОДЛОГО–ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ”** мөрийн хөтөлбөрөө өргөн барьж байгаадаа баяртай байна.

Бид энэ удаагийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Дархан хотын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө /2020-2035 он/, Орхон сумын хөгжлийн стратеги төлөвлөгөө 2016-2025 он болон бусад хөгжлийн суурь баримт бичгүүдийн зорилго, зорилтуудтай уялдуулан иргэдийн санал, эрэлт шаардлагад нийцүүлэн боловсрууллаа.

Мөрийн хөтөлбөрийн гол үзэл баримтлал нь хүнээ хөгжүүлэх замаар орон нутгийн хөгжлийг хурдасгаж, шинэ техник, технологи, инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэн хөгжлийн тэргүүлэх салбаруудыг бодлогоор дэмжиж, нэмүү өртөг шингэсэн үйлдвэржилтийн тогтвортой бодлого барьж, ажлын байруудыг бий болгон иргэдээ ажилтай, орлоготой байлгаж амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэж байгаа юм.

Энэ ч утгаараа манай намын мөрийн хөтөлбөр нь аймаг, сумын хөгжлийн төлөвлөгөөнд суурилсан, хэрэгжих бүрэн боломжтой, сумын цаашдын хөгжлийг хурдасгах бодлогын баримт бичиг болж чадсан.

Тус мөрийн хөтөлбөр нь ард иргэдийнхээ аж амьдралыг сайжруулах чиглэлээр өмнө нь хэрэгжүүлж байсан төсөл, хөтөлбөр, бүтээн байгуулалтын ажлын шууд үргэлжлэл болж буйгаараа онцлог юм.

Манай нам бүхий л цаг үед ард иргэдийнхээ өмнө хариуцлагаа гүнээ ухамсарлаж, тэднийхээ итгэлийг дааж, нутгийнхаа үүсэл, хөгжлийн түүчээ нь байж ирсэн бөгөөд цаашид ч хөгжилд хөтлөгч улс төрийн гол хүчин байж чадна гэдгээ илэрхийлж байна.

Нийт Орхончууд Та бүхнийгээ Монгол Ардын Намын хорооноос дэвшүүлсэн мөрийн хөтөлбөртэй сайтар танилцаж, улмаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгох сонгуульд нэр дэвшиж буй төлөөлөгчдийг маань дэмжиж, саналаа өгнө гэдэгт итгэж байна.

Төр **тогтвортой** байснаар төрийн бодлогын залгамж чанар**тогтвортой** хадгалагдаж, хөгжил **тогтвортой**, хурдацтай байх болно.

ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХҮЧЭЭ НЭГТГЭЭ!

НЭГ. ТӨРИЙН УДИРДЛАГА

Хүний эрх, эрх чөлөөг хангасан ухаалаг, тогтвортой засаглал бүхий цахим технологид суурилсан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлд тулгуурласан төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.

1.1 Иргэдэд ээлтэй төрийн үйлчилгээ

1.1.1 Орон нутгийн хөгжлийн асуудлаар аливаа бодлогын баримт бичгүүдийг улс, аймгийн хөгжлийн урт хугацааны бодлогын үзэл баримтлалд тулгуурлан боловсруулж, төслийг иргэдээрээ урьдчилан хэлэлцүүлж, гарсан санал дээр үндэслэн шийдвэр гаргаж, хэрэгжүүлнэ.

1.1.2 Төр, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжинэ.

1.1.3 Төрийн жинхэнэ албан хаагчдыг сонгуулийн үр дүнгээс үл хамааран ажил гүйцэтгэх чадвар, шатлан дэвших зарчмын дагуу сонгон шалгаруулалтаар томилж, төрийн албанд тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

1.1.4 Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулж, хөнгөлөлттэй орон сууцаар хангах **бодлого** баримтлана.

1.1.5 Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэгийг дээшлүүлнэ.

1.1.6 Төрийн албан хаагчдыг тасралтгүй сурган хөгжүүлж, мэдлэг, чадвар, хандлагыг шинэчилнэ.

1.1.7 Төсөл, тендерийн шалгаруулалтыг ил тод, нээлттэй явуулж, тусгай сангуудын үйл ажиллагааг иргэд, хувийн хэвшлийг дэмжихэд чиглүүлж, олон нийтэд нээлттэй, хяналттай байлгана.

1.1.8 Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн аливаа үйлдэл, эс үйлдэхүйг таслан зогсооно.

1.2 Ухаалаг төрийн үйлчилгээ

1.2.1 Төрийн цахим үйлчилгээг шуурхай авах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор **“Нэг иргэн – Нэг бүртгэл”** хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.2.2 Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, **“Түгжрэлгүй төрийн үйлчилгээ”** нэвтрүүлж, зарцуулах хугацааг богиносгож, иргэдийн сэтгэл ханамжийн хөндлөнгийн судалгааг хагас жил тутамд авч, үнэлгээний системийг нэвтрүүлнэ.

1.2.3 Нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор **“Эрх зүйн хөтөч”** төсөл хэрэгжүүлнэ.

1.2.4 Хууль хяналт болон цэрэгжсэн байгууллагын материаллаг баазыг дэмжиж, хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

1.2.5 Гамшгийн үед ажиллах мэргэжлийн ангийн техник хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлнэ.

1.2.6 Аюулгүйн нөөц бүрдүүлэх, хуваарилах, зохицуулалт хийх, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулна.